

## ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төсөл боловсруулсан тухай*

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг нийгмийн хамгаалал болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно” гэж заасан.

Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 16 дугаар тогтоолоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллын хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоон, мөрдөж байна. Энэхүү тогтоол нь Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5448 дугаарт бүртгэлтэй болно.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэлэлцэн баталсан. Дээрх хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль/шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.7-д “Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно” гэж заасан.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтоолын төсөл боловсруулав.

Одоогийн мөрдөж байгаа тогтоолоор даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг нэг ор хоногт 60 000 (жаран мянга) төгрөгөөр тооцож үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санхүүжүүлж байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2022 онд 2053 иргэнд сувиллын зардалд 1.1 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд 2023 онд 2.1 тэрбум төгрөг төсөвлөснөөс 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 1156 иргэнд 741.8 сая төгрөг зарцуулсан байна. 2024 онд 2.2 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн байна.

Шинээр мөрдөгдөх тогтоолд сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх сувиллын газруудын одоогийн мөрдөгдөж буй үнэ тариф, саналын дагуу нэг ор хоногт 70 000 (далан мянга) төгрөгөөр тогтоосон бөгөөд 10 000 (арван мянга) төгрөг буюу 16.6 хувиар нэмэгдүүлсэн болно.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ батлагдсанаар нийгмийн даатгалын сангийн батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлж, нэмэлт зардал гарахгүй байх боломжтой юм.

#### ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ